**БНМАУ**

# УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 6 сарын 06 | №147 | Улаанбаатар хот

03 - 22 - 143

Районы боловсролын байгууллагын хангамж үйлчилгээний зохион байгуулалтыг өөрчлөх тухай

Хот, районы боловсролын газар, хэлтсүүдийн зохион байгуулалтанд зарим өөрчлөлт оруулах шаардлагатай байгааг үндэслэн Улаанбаатар хотын ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Районуудын сургууль, цэцэрлэгүүдийн хангамж, үйлчилгээний төвүүдийг 6 дугаар сарын 15-наас татан буулгаж Боловсролын хэлтэстэй нэгтгэн ажиллуулахыг районы Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.

2. Районы боловсролын хэлтсийн үлгэрчилсэн дүрмийг нэгдүгээр хавсралтын ёсоор баталсугай.

3. Зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбогдуулан Хотын Боловсролын газрын сарын цалингийн санг 17,0 мянган төгрөгөөр баталсугай.

4. Районы боловсролын хэлтсийн сарын цалингийн санг баталж өгөхийг хотын санхүүгийн газар /н.Гонгор/-т даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан БНМАУ-ын Сангийн яам, Боловсролын яамны зөвшөөрөл саналыг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, БНМАУ-ын Сангийн Яам, Боловсролын яамны 1989 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хамтарсан 06/21/18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА — Л. ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА — Ц. БОЛДСАЙХАН

Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны [illegible] дугаар тогтоолын хавсралт

# УЛААНБААТАР ХОТЫН РАЙОНЫ АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

## Нэг.<u>Нийтлэг үндэслэл</u>

1.Улаанбаатар хотын районы ардын хурлын гүйцэтгэх захиргааны боловсролын хэлтэс нь районы нутаг дэвсгэрт боловсролын асуудлыг хариуцсан төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

2.Боловсролын хэлтэс нь тухайн хурлын нутаг дэвсгэрт сургуулийн насны хүүхдийг бүх нийтээр хамран сургах, хүүхэд залуучуудад суурь боловсрол олгох ажлыг зохион байгуулахын зэрэгцээ тэдний авъяас чадварыг бүх талаар хөгжүүлэх, хөдөлмөрийн болон үндэстний ёс заншил, өв уламжлалаар хүмүүжүүлэх, хөдөлмөрчдийн ерөнхий боловсролын түвшинг дээшлүүлэх, сургалт хүмүүжлийн ажлын материаллаг баазыг бэхжүүлэх, улсаас хуваарилсан төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад оршино.

3.Боловсролын хэлтэс нь үйл ажиллагаандаа БНМАУ-ын Боловсролын хууль, бусад хууль тогтоомж, эрхийн акт, энэ дүрэм, Боловсролын сайд, Хотын боловсролын газрын даргын тушаал, заавар, хот, районы хурал, түүний гүйцэтгэх захиргааны тогтоолыг удирдлага болгон ажиллана.

4.Боловсролын хэлтэс нь районы ардын хурал, түүний гүйцэтгэх захиргаа, хотын Боловсролын газрын өдөр тутмын удирдлагын дор ажиллаж, тэдгээрт ажлаа хариуцан тайлагнана.

5.Боловсролын хэлтсийн даргыг томилох, чөлөөлөх асуудлыг районы ардын хурлын гүйцэтгэх захиргаа, хотын Боловсролын газартай санал тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж районы ардын хурлын чуулганаар батална.

6.Боловсролын хэлтсийн дарга эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана.

7.Боловсролын хэлтэс тогтоосон журмын дагуу хийсэн тамга, тэмдэг, хуудас, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Боловсролын хэлтсийн эрх үүрэг

Боловсролын хэлтэс дор дурьдсан үүрэг гүйцэтгэнэ.

а/ Нутаг дэвсгэртээ хотын ардын хурлын гүйцэтгэх захиргааны харъяалалын боловсрол, сургуулийн өмнөх насны хүүхдийн болон сургуулиас гадуур хүмүүжил олгох байгууллагыг удирдаж сургуулийн насны хүүхдийг цацарлагт хамруулах ажлыг зохион байгуулж хүүхдийг сургуульд бэлтгэх бэлтгэлийг хангах, сургуулийн насны хүүхдэд нийтээр нь суурь болон ерөнхий дунд боловсрол, мэргэжил, мэргэжлийн чиг баримжаа, ёс суртахуун, бие бялдар, гоо зүйн хүмүүжил олгох.

б/ Улс орны нийгэм, эдийн засгийн болон боловсролын хөгжлийн чиглэлтэй уялдуулан районы боловсролын байгууллагуудыг хөгжүүлэх үзэл баримтлал, төлөвлөгөө боловсруулан мөрдөх.

в/ БНМАУ-ын боловсролын хууль, боловсролын талаар гарсан төр засгийн тогтоол шийдвэрийг районы нутаг дэвсгэрт сурталчлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж биелэлтэд хяналт тавих.

г/ Районы ерөнхий боловсролын сургуулиудын хэв шинж, бүтцийг өөрчлөх, сургалт хүмүүжлийн хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгох, шинээр барих сургууль, цэцэрлэгийн байршлыг тогтоох, их засвар хийлгэх, хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж хуваарилах талаар улсын төлөвлөгөө төсөвт тусгуулах санал гаргах.

д/ Районы сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын хөрөнгө материал, хүн хүчинд тулгуурлан төлбөртэй сургалт үйлчилгээ явуулах, хүн амын хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, туслах аж ахуй хөгжүүлэх ажлыг зохион байгуулах.

е/ Хүүхэд залуучуудын чөлөөт цаг, сурагчдын өвөл, зуны амралтыг зөв зохион байгуулж, тогтоосон журмын биелэлтэд хяналт тавьж, шаардагдах арга хэмжээ авах,

ж/ Районы хэмжээнд эрхэлсэн асуудлын чиглэлээр үзэсгэлэн, хурал семинар, зөвлөлгөөн, мэргэжлийн болон спорт, уран бүтээлийн уралдаан тэмцээн, тойрон аялал, төрөл бүрийн олимпиад зохион байгуулах.

з/ Багш, сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжил, сурган хүмүүжүүлэх ур чадварыг дээшлүүлэх, үр бүтээлтэй ажиллуулах, сахилга хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авч байх,

и/ Сурагчдын хичээл, үйлдвэрлэлийн дадлагын үед хөдөлмөр хамгаалалын дүрэм, зааврыг чанд мөрдүүлэх арга хэмжээ авч байх,

к/ Өнчин болон асрах хүнгүй хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилуулах, тэтгэвэр хүүхдийг ясли, цэцэрлэг, дотуур байртай сургуульд оруулах, асрамжийн газарт шилжүүлэх, хүүхдийг хараа хяналтгүй байлгах явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж шаардлагатай арга хэмжээ авч байх,

л/ Сургууль, цэцэрлэгийн хамт олон, багш, сурган хүмүүжүүлэгчид, хөдөлмөрчдийн санал, өргөдөл гомдлыг хүлээн авч хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх талаар шаардлагатай арга хэмжээ авах,

м/ Районы сургууль, цэцэрлэгүүдийн жилийн төсөв, төлөвлөгөө, тайланг нэгтгэж холбогдох байгууллагуудаар хянуулж батлуулах, батлагдсан төсвийг хуваарилах, зарцуулах.

н/ Районы сургууль, цэцэрлэгийн хэрэгцээнд шаардагдах бараа материалыг тэдний захиалгын үндсэн дээр олж бэлтгэх, хуваарилах,

р/ Сургууль, цэцэрлэгийн санал хүсэлтийн дагуу үйлчилгээг хөнгөн шуурхай, боловсронгуй болгох өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад үзлэг шалгалт хийж хяналт тавих, энэ талаар тэргүүн туршлага давшилттай арга хэлбэр, шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтыг нэвтрүүлэх ажлыг шууд хариуцана.

Гурав. <u>Районы боловсролын хэлтсийн эрх</u>

а/ Боловсролын асуудлаар районы үйлдвэр, албан байгууллагын ажлыг шалгах, илтгэл сонсголыг авч хэлэлцэх үүрэг даалгавар өгч биелэлтийг хангах,

б/ Боловсролын хэлтсийн хэмжээнд хуваарлсан төсөвт хөрөнгийг тогтоосон журмын дагуу зарцуулахаар харилцах данс, хөрөнгө материалын гүйлгээнд I-р гарын үсгийг хэлтсийн дарга, 2-р гарын үсгийг хэлтсийн эрхлэх нягтлан бодох зурна.

в/ Үйлдвэр, албан байгууллага, пүүс, хоршоололуудтай гэрээ хэлцэл хийх.

x x x